

СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

а/ Сумын ИТХ-ын ажлын чиглэлээр: 2022 оын 10 сарын 3-ны өдөр сар бүрийн ажлын эхний өдөр зохион байгуулдаг “УДИРДАХ АЖИЛТНЫ МЭДЭЭЛЛИЙН ЦАГ”-аар байгууллагын дарга нар хуралдаж цаг үеийн мэдээлэл болон нэн тэргүүнд тулгамдаж байгаа асуудал болоод өвөлжилтийн бэлтгэл, бэлэн байдлын талаар ярилцлаа.

Аймгийн ИТХ-ын Хяналт-Шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг 4 хүний бүрэлдэхүүнтэй ирж 10 сарын 24-ны өдөр Сумын ИТХ-ын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж зөвлөг туслах үйлчилгээг үзүүлж ажилласан.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын хуулиар олгогдсон эрх, үүргийн дагуу хурлын шийдвэрийг иргэд, сонгогчидодоо тайлбарлан таниулах, сонгогдсон тойрогтоо хийж хэрэгжүүлсэн ажлын талаар багаас сонгогдсон ИТХ-ын төлөөлөгч нарын “Төлөөлөгч нэг өдөр” арга хэмжээг 10 сарын 26-ны өдрөөс эхлэн сумын төвийн 4 багт хийхээр Удирдамжаа гарган ажиллаж байна.

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

2022 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд МУЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 10 ны өдрийн А/343 дугаар захирамжаар батлагдсан журмыг тус тус баримтлан ажлын хэсэг төсөвт 5 байгууллага, ЗДТГын 10 мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд 2022 оны 10 сарын 10-15 хооронд ХШҮ хийж 10 сарын 20 ны өдөр Засаг даргын зөвлөлд танилцуулан ажиллалаа.

10 дугаар сарын 20 нд дарьганга суманд зохион байгуулагдсан хунгийн чуулганд соёлын төв, здтг хамтран 6 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.

Хүүхэд хамгааллын хамтарсан багийн 5 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Сүхбаатар сумын Улаанхудаг гэх газраас ЕБС ийн 3,4 ангийн 1 айлын 2 сурагч сургууль завсардаад байсныг 10 дугаар сарын 14 ны өдөр очиж авчран ЕБС д хүлээлгэн өглөө. Мөн 10 сарын 15 ны өдөр олон улсын байгууллагын тусламжаар ирсэн хүүхдийн нарийн мэргэжлийн эмчид болон эхо оношлогоонд үзүүлж зөвлөгөө авч ажилласан. Дээрх 2 сурагчид ЗДМХ ийн хамтарсан багийн зардлаас 100,000 төгрөгний үнэ бүхий ариун цэврийн хэрэгсэл, дотуур хувцас, хичээлийн хэрэгсэл авч өгч ажиллалаа.

10 дугаар сард: Ирсэн бичиг–15, Явсан бичиг – 10, Хариутай бичиг – 4
Хугацаандаа явсан бичиг – 4, Хугацаа болоогүй бичиг – 0, Хугацаа хэтэрсэн бичиг – 0 байна.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:

Бүх төсөвт байгууллагууд 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг гаргаж Сангийн яамны төсөвт байгууллагын тайланд шивж илгээлээ.

2023 онд ОНХС хөрөнгөөр 14 ажлыг хийхээр 237.0 сая төгрөг батлагдсанаас 10 сарын байдлаар 5 ажил бүрэн хийгдсэн, 5 ажил хийгдэж дуусаагүй, нийтдээ 113.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Сумын татварын орлогын агнуурын нөөцийн төлбөр дансанд төлөвлөгдөөгүй орлого болох 5 шонхорын төлбөр 159.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

Улсын төсвийн 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн 2.5 км хатуу хучилттай авто замын ажлыг Улаанбаатар хотын "Ханан салхит" ХХК хийж гүйцэтгэж байна.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Ахмад настны тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар тус тус сонсгол мэдээллийн цагаар болон Халзан сумын ЗДТГ-ын албан ёсний вэб хуудсаар дамжуулан мэдээлэл өгч ажиллалаа.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Ерөнхий боловсролын сургууль: БҮТ-өөс зохион байгуулсан ССҮ-нд амжилттай шалгагдаж, гүйцэтгэлийн дунджаар аймгийн хэмжээнд 5-р байр эзэлсэн. Гүйцэтгэлийн үнэлгээгээр 7 багш буюу нийт багш нарын 50% нь 1-2 дугаар түвшинд үнэлэгдсэн. 1-р ангийн 34 сурагчдаас "Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх" үнэлгээний шалгалтын 7 төрлөөр авсан.

МХБХ-ны "ХӨВГҮҮДИЙН ЦОМ-2022" УАШТ-ний U14 насны ангилалд 9а ангийн сурагч Э.Амгаланбаатар амжилттай оролцож мөнгөн медалийн эзэн боллоо.

Сүхбаатарын өнгө сонины 5 жилийн ойд зориулсан "Найргийн орны найрагч хүүхдүүд" Уран уншлагын наадам өчигдөр буюу 10 дугаар сарын 20-ны өдөр Сүхбаатар аймгийн Баруун-урт хотод амжилттай болж өнгөрлөө. 6-9 ангийн насны төрөлд 8а ангийн сурагч Мөнхбаатарын Үүрийнцолмон "Гутгаар" байр эзэллээ.

Сүхбаатар аймгийн "НЭГДҮГЭЭРТ_ХҮҮХЭД" VII чуулганд сумын Засаг дарга Г.Алтансүх сургуулийн дотуур байрын багш болон 6-9-р ангийн төлөөлөл 5 сурагч оролцож тулгамдаж буй асуудлаа танилцуулсан.

Багш нарын баярыг угтан ДЗАН-ээс зохион явуулсан "Эцэг эх-Бид Хамтдаа Сонсьё Ярилцъя" хөтөлбөрт арга хэмжээ сонирхолтой, сургамжтай санаа авахаар сайхан болж өнгөрсөн. Энэхүү арга хэмжээнд нийт 58 эцэг эх хүрэлцэн ирж, нэг өдрийг хамтдаа өнгөрүүлсэн.

Дэлхийн багш нарын 28 дахь өдөр, Монголын багш нарын 56 дахь өдрийн баярын өдрийг тохиолдуулан "СУРАГЧ НАСАА ДУРСАХУЙ" арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 25-70 насны сурагчид оролцож сурагч насаараа аялж 2 цагийн хичээлд суун хүүхэд насны үеэ дурслаа. Энэ үеэр сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаатай танилцан үдийн хоол хөтөлбөрт хамрагдав.

Соёлын чиглэлээр: 10 дугаар сарын 1 нд Ахмадын баярын хурал баярт зориулсан үдшийн цэнгүүн, 10 дүгээр сарын 05 нд Багш нарын баярын хурал баярт зориулсан үдшийн цэнгүүнийг тус тус зохион байгуулан ажилласан байна.

Сүхбаатар аймаг кино театртаас CINEMA TICT кино үзвэр гаргав.

Мөн Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн А/517 дугаар захирамжийн хүрээнд Угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг таниулан сурталчлах, айл өрх, иргэдийн дунд угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлэх, угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлэх зорилгоор Халзан сумын ЗДТГ, Соёлын төв, Халзан сумын Насан туршийн боловсролын нэгж, Сүхбаатар аймгийн Насан туршийн боловсрол төв хамтран "Угийн бичгээ хөтөлж Удмын сангаа хамгаалъяа" сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг Насан туршийн боловсрол төвийн сургалтын менежер П. Уянга удирдан зохион байгуулсан бөгөөд угийн бичиг хөтлөх арга ач холбогдол, угийн бичиг хөтлөх журам, арга зүйн чиглэлээр мэдлэг олгож, дадлагаар баталгаажуулан үнэлж дүгнэж ажиллав. Сургалтад Халзан сумын төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчид хамрагдав.

Номын сангийн уншлагын танхимаар 56 уншигч үйлчлүүлсэн бөгөөд үүнээс сургуулийн насны 41 хүүхэд, насанд хүрэгч 15 иргэн үйлчлүүлж гэрээр ном олгох үйлчилгээнд 2ш ном олгосон байна.

Сүхбаатарын өнгө сонины 5 жилийн ойд зориулсан "Найргийн орны найрагч хүүхдүүд" уран уншлагын наадам Баруун-урт хотод 10 дугаар сарын 20ны өдөр болж өндөрлөлөө сумаас сум цэцэрлэгийн нас, 1-5 анги, 6-9 анги гэсэн 3 насны ангилалаар 10 яруу найрагч хүүхдүүд оролцсноос 6-9 ангийн төрөлд Л.Дэлгэрмаа багштай 8а ангийн сурагч М.Үүрийнцолмон "ГУТГААР" байр эзэлж амжилттай оролцлоо.

Хүнс хөдөө аж ахуйн жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр: 2022 оны 10-р сарын 25-ны байдлаар нийт 5 зээлдэгч байгаагаас 2022 оны 10 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 2 хүнээс 1100000 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна. Нийт зээлдүүлэгч нартай утсаар болон биеэр очиж уулзан хугацаандаа зээлээ эргэн төлөх талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.

Сумын ИТХ-н хурлын тогтоолоор 10 сарын 04 өдөр Хоршоо хөгжүүлэх сангийн сонгон шалгаруулах комисс хуралдаж 11 төсөл ирсэнээс 6 зээлдэгчид 110,000,000 олгохоор шийдвэрлээд байна.

Сумын хүнсний гол нэрийн нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг 1 аймгийн ХХААГазарт мэдээлж байна.

Баруун-Урт суманд 10 дугаар сарын 5 өдөр ХХААГ, БОАЖГ, УЦУОШГ, Мал эмнэлэг, ГХБХБГ нарын хамтарсан Малдчын зөвлөгөөнд Засаг дарга болон 5 мэргэжилтэн, 7 малчдын төлөөлөл оролцож бэлчээрийн доройтол, худаг усны асуудал, малын мах, түүхийн эдийн үнэ, малын тоо чанар, малчдын бүлэг хоршоо чиглэлээр санал бодлоо илэрхийлж оролцлоо.

Сүхбаатар аймаг ХХААГ, Эрүүл мэндийн газар, МХГазар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Стандарт хэмжил зүйн газар сумдын ЗДТГазар хамтран 2022.10.23 өдрүүдэд "Бүсийн тогооч, зөөгчийн сургалт ур чадварын уралдаан 2022" арга хэмжээг Улсын тэргүүний Түмэнцогт суманд амжилттай зохион байгуулагдаж сумаа төлөөлөн 5 тогооч оролцож сургуулийн хоолны төрөлд З.Солонго дэд байр, Урлагийн наадамд багийн дүнгээр 3-р байр, Аймгийн Засаг даргын жуух бичгээр цэцэрлэгийн тогооч Д.Батцэцэг, ХААТасгийн жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн Г.Бямбацэцэг Залуучдын холбооны 100-н жилийн медалиар тус тус шагнагдлаа.

Мал эмнэлэгийн чиглэлээр: "Малчдын зөвлөгөөн-2022"ийг зохион байгуулж Мал эмнэлгийн газрын Мал амьтны эрүүл мэндийн албаны дарга Ж.Сундуй, Мал эмнэлгийн улсын байцаагч Ариунсүх нар орлоцож мал амьтны

эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, малын гарал үүслийн гэрчилгээний талаар мэдээллийг ард иргэдэд өгсөн.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 33504 охин төл хамрагдаж 37200 тун вакцин зарцуулж хэвийн хорогдлоор 4871 тун устгасан байна. Мал эмнэлгийн цахим системд тулгалт хийж аймгийн мал эмнэлгийн газарт холбогдох бичиг баримтыг хүргүүлээд байна.

Шүлхий өвчнөөс сэргийлэх 21000 тун вакцин татан авч сумын засаг даргын 2022 оны 10 сарын 18 ны өдрийн А/135 тоот захирамжийн дагуу 5 хэсэг гарч 230 өрхийн 14124 үхэр, 6800 тугал, нийт 20324 мал хамрагдахаар хувиар хийгдээд байна.

124 өрхийн 9041 үхэр, 3109 тугал хамрагдаж тарилгын явц 58,1 хувьтай явагдаж байна.

Байгаль орчны чиглэлээр: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Тарьц суулгацын “-үзэгслэн худалдаанд 2022.10-р сарын 07-нд зохион байгуулагдсан нээлтийн ажилгаанд засаг даргын орлогч, байгаль хамгаалагчийн хамтаар оролцон орон нутагтаа “Намрын мод тарих өдрийг зохион байгууллаа. Энэ аяны хүрээнд ААнэгж-4, айл өрх-60, байгууллага-4, Иргэн-142 хамрагдан 4-н төрлийн 540 суулгацыг технологийн дагуу суулган, хашаа хайлс татан усалгаа хийлээ.

Усан сан бүхий газар усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх усны нөөцийг бохирдож, хомсдохоос хамгаалах ажлыг зохион байгуулж Аймгийн БОАЖГ-ын санхүүжилтээр 4-н ширхэг самбарыг хийлгэн сумын төвийн ус түгээх худгуудад байршууллаа. Усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтийн эрүүл ахуйн бүс дэх айл өрх, АА-нэгж, байгууллагын нүхэн жорлон, хаягдал усны цооногын судалгааг газрын даамалтай хамтран гаргалаа.

БНАТ-1.2 маягтыг гарган “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг бүдүүлэх, тайлагнах журмыг “-г хэрэгжүүлэх 2023 оны орлого зарлагын төлөвлөгөөг сумын санхүүгийн мэргэжилтэн, татвар, газрын даамал, холбогдох мэргэжилтэн нартай хамтран гарган аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлээ.

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:

М.БАТБЭХ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
Д.ДАЙРИЙМАА

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

